



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

/2024 оны I улирал/

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/97 дугаар тушаалаар томилогдсон Ёс зүйн дэд хороо нь Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, төрийн албан хаагчийн сахилга хариуцлага, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан нэгдүгээр улирлын байдлаар төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүйд холбогдох 11 өргөдөл гомдлыг Ёс зүйн дэд хорооны 3 удаагийн хурлаар хэлэлцэн холбогдох дүгнэлтийг шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан, албан хааг, гомдол гаргагчид хүргүүлсэн.

Дүгнэлтийн дагуу 2 албан хаагчид Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан ёс зүйн хариуцлага тооцож, 5 албан хаагчид ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж хүргүүлсэн.

Мөн Төрийн албаны зөвлөлөөс боловсруулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын төслүүдэд тусгах саналыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.



ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО
2024 он